



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/492

Булган сум

Цагдаагийн газарт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Булган аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ын 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын алба хаагчдын өдөр тутмын гарын авлага 120 боть бүтээлийг худалдан авахад шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

